

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

(Шинэчилсэн найруулгын төсөл)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно.

1.3. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

1.4. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага хянаж, батална.

1.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь доорх хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1.5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

1.5.2. Нөхөн сэргээх арга хэмжээ

1.5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

1.5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ

1.5.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

1.5.6. Химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ

1.5.7. Хог, хаягдлын менежмент

1.5.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

1.5.9. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

1.5.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

1.6. Энэ журмын 1.5.10 – т заасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт хийх үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана. Үүнд:

1.6.1. Газрын гадарга, хэвлий

1.6.2. Агаарын чанар, дуу шуугиан

1.6.3. Гадаргын ус

1.6.4. Газрын доорх ус

1.6.5. Хөрсөн бүрхэвч

1.6.6. Ургамлан нөмрөг

1.6.7. Амьтны аймаг

1.6.8. Цацрагийн түвшин /Цацраг идэвхт ашигт малтмал хайх, олборлох төсөлд хамаарна/

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ

2.1. Нийтлэг шаардлага

2.1.1. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж болон, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын 4 дүгээр хэсгийг баримтлан жил бүр 12 дугаар сард багтаан боловсруулна.

2.1.2. Шинээр эхлэн хэрэгжүүлж байгаа төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг уг төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулснаас хойш 1 сарын дотор боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлж батлуулна.

2.1.3. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна.

2.1.4. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд нь хэрэгжүүлж буй төсөлдөө байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө хийлгэн, батлуулсны дараа тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр хариуцан боловсруулж, ерөнхий үнэлгээ баталсан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлж, батлуулна.

2.1.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн танилцуулга, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж нутгийн байгаль орчны төлөв байдлын танилцуулга, энэ журмын 1.5 – д заасан бүрдэл хэсгүүд, баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгана.

2.1.6. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд хэрэгжүүлж буй төсөл нь эдийн засаг, зах зээлийн хямрал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ зах зээл дээр унасан, байгалийн болон тухайн бүс нутаг, хүн амыг хамарсан өвчин, тахал, онцгой нөхцөл байдал үүссэний улмаас зогсонги байдалд орсон бол энэ талаараа ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хандан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон талаараа мэдэгдэж, дээрх шалтгаан арилах хүртэл түр хойшлуулж болно.

2.2. Тусгай шаардлага

2.2.1. Уул уурхайн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах тусгай шаардлагыг хангасан байна:

2.2.1.1. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хариуцсан орон тооны байгаль орчны асуудал хариуцсан нэгж эсхүл ажилтантай байна.

2.2.1.2. Уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн зам, дэд бүтцийн зурвас газарт хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд, туслан гүйцэтгэгч хуулийн этгээдүүдийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал нэгтгэн тусгана.

2.2.1.3. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлагдсан хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна.

2.2.1.4. Алтны шороон ордыг олборлох төслийг эхлүүлэхээс өмнө тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн арга хэмжээг нарийвчлан төлөвлөж, батлуулна.

222. Үйлчилгээ, аялал жуулчлалын төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах тусгай шаардлагыг хангасан байна:

222.1. Үйлчилгээ, аялал жуулчлалын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухайн жилийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна.

222.2. Үйлчилгээ, аялал, жуулчлалын төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж буй төслийнхөө тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд ус хангамж, ариутгах татуургын байгууламж, хаягдал ус цэвэрлэх технологи, техникийн үзүүлэлтүүд, ахуйн гаралтай шингэн болон хатуу хог хаягдлын менежментийг нарийвчлан тусгана.

222.3. Батлагдсан байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, түүний зөвлөмжид тусгагдаагүй тохиолдолд энэ журмын 1.5.3, 1.5.4, 1.5.6, дахь арга хэмжээг төлөвлөхгүй байж болно.

223. Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараахь тусгай шаардлагыг хангасан байна:

223.1. Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бэлтгэл, барьж байгуулах болон үйлдвэрлэл, ашиглалтын үе шатны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна.

223.2. Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн хортой болон аюултай бодисыг тухайн жилд хэрэглэх хэмжээ, тээвэрлэлт, хадгалалт, зориулалт, саармагжуулалт, устгалт, сав баглаа боодлын хадгалалт, устгалтын талаар нарийвчлан тусгана.

224. Хөдөө аж ахуй, үйлдвэрийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараахь тусгай шаардлагыг хангасан байна.

224.1. Хөдөө аж ахуй, үйлдвэрийн төслийн хувьд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухайн жилийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна.

224.2. Хөдөө аж ахуй, үйлдвэрийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн гаралтай бордоо, ургамал хамгаалал, хортон шавьжтай тэмцэхэд ашигладаг химийн хортой болон аюултай бодисыг тухайн жилд

хэрэглэх хэмжээ, тээвэрлэлт, хадгалалт, зориулалт, саармагжуулалт, устгалт, сав баглаа боодлын хадгалалт, устгалтын талаар нарийвчлан тусгана.

2.243. Батлагдсан байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй тохиолдолд энэ журмын 1.5.3, 1.5.4, 1.5.6 дахь арга хэмжээг төлөвлөхгүй байж болно.

2.244. Хөдөө аж ахуй, үйлдвэрийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд ашиглах усны эх үүсвэр, хэмжээ, ус цэвэршүүлэх технологи, усыг эргүүлэн болон дахин ашиглалтын талаар нарийвчлан тусгана.

2.245. Хөдөө аж ахуйн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хөрс хамгаалал, талбайн сэлгэн ашиглалт, уринш болон цэвдэгш, тарих ургамлын сорт талаар нарийвчлан тусгана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАЖ, БАТЛАХ

3.1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, батлах нийтлэг шаардлага

3.1.1. Тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж болон батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага олгоно.

3.1.2. Нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.

3.1.3. Энэхүү журамд заасан агуулга, шаардлагыг хангаж боловсруулаагүй бол тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

3.1.4. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар 12 дугаар сарын 1-ний дотор байгуулж, ажиллуулан дүгнэлтийг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын дарга, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны асуудал хариуцсан улсын байцаагч, сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн, сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч, нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл орно.

3.1.5. Уул уурхайгаас бусад салбарын төсөл хэрэгжүүлэгчээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар 12 дугаар сарын 1-ний дотор байгуулж, ажиллуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 31-ний дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн

байгууллагын дарга, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны асуудал хариуцсан улсын байцаагч, сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн, сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч, нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл орно.

3.1.6. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудлыг эрхэлсэн байгууллагын дарга ажлын хэсгийн нарийн бичгийн дарга байна.

3.1.7. Нөлөөллийн бүсэд оршин суугч иргэний төлөөллөөс бусад ажлын хэсгийн гишүүд нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, үнэн зөв, бодит дүгнэлт гаргах чадвартай, байгаль орчны болон тухайн салбарын хууль тогтоомжийн талаар бүрэн мэдлэгтэй, ажлын туршлагатай хүн байна.

3.1.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхдээ зөвхөн тухайн оны батлагдсан менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын гүйцэтгэлийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг заавал байлцуулан шалгаж, дүгнэнэ.

3.1.9. Стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь үзэж дүгнэлт гаргах ажлын хэсэгт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулна.

3.1.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авч, төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн цахим шуудангийн хаягаар төлөвлөгөөг хүлээж авсныг баталгаажуулсан хариуг тухай бүр илгээнэ.

32. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, батлах тусгай шаардлага

3.2.1. Уул уурхайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь хянаж баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсэг тухайн төсөл хэрэгжүүлэгчийн төлөөллийг байлцуулан хянаж баталгаажуулсан дүгнэлтээ дараа оны 2 дугаар сарын 1-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлээгүй бол тухайн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон нутаг хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болно.

3.2.2. Уул уурхайн олборлох төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад ирүүлж, уг аудитын тайлан, аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь дахин шалгахгүйгээр хүлээн авч болно.

3.2.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан, батална.

3.2.4. Ойн сан бүхий газарт хэрэгжиж буй төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр дүгнэх ажлын хэсэгт тухайн нутаг дэвсгэрийн ойн ангийн төлөөллийг оруулна.

Дөрөвдүгээр бүлэг. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах

4.1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан ирүүлэх нийтлэг шаардлага

4.1.1. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг 12 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

4.1.2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаар төсөл хэрэгжүүлэгчийн цахим шууданд нэн даруй хариу мэдэгдэнэ.

4.1.3. Уул уурхайн олборлох төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн талаар БОХ-3 маягтын дагуу холбогдох мэдээллийг гаргаж, тухайн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт жил бүрийн 12 дүгээр сарын 1-ний дотор хүргүүлэх ба уг маягтыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал хавсаргана.

4.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хянаж, баталгаажуулахад тавигдах шаардлага

4.2.1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан тухайн төсөлд тохирох загвараар дүгнэж, ажлын хэсгийн гишүүд гарын үсгээ зурж, баталгаажуулан, цахим мэдээллийн санд оруулж, төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим хаяг руу мэдэгдэнэ. Ажлын хэсэг дүгнэлт гаргаснаас хойш ажлын 5 хоногийн дотор төсөл хэрэгжүүлэгчид цаасаар хүргүүлнэ.

4.2.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгийн биелэлтийг энэхүү журмын 4-р хавсралтад заасны дагуу хувиар тооцож, үнэлэх ба бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээ 80 хувиас дээш байвал батална.

4.2.3. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн тухайн жилийн байгаль орчны төлөвлөгөөний биелэлт 80 хувь хүрээгүй, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол барьцаа хөрөнгийг зарцуулж, эрх бүхий байгууллагаар хангалтгүй хийгдсэн ажлыг гүйцэтгүүлэх үндэслэл болно.

4.2.4. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний баталгаажих нүүр хуудасны загварыг журмын 1 дүгээр, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нүүр хуудасны загварыг журмын 2 дугаар, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, тайлангийн агуулгыг журмын 3 дугаар, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудасны загварыг журмын 4 дүгээр хавсралтад заасан загварын дагуу тус тус гаргана.

Тавдугаар бүлэг. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн сан

5.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санг төрийн захиргааны төв байгууллагууд, иргэн, хуулийн этгээдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, шийдвэр гаргах үйл ажиллагааг хурдан шуурхай, ил тод болгох, оролцогч талууд, нөлөөллийн бүс дэх иргэдийн оролцоог хангах зорилгоор байгуулна.

5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд дор дурдсан мэдээллийг төсөл хэрэгжүүлэгч бүр заавал оруулна.

5.2.1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар

5.2.2. Тусгай зөвшөөрлийн хуулбар

5.2.3. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.2.4. Ус ашиглах дүгнэлт, сум эсхүл сав газрын захиргаатай байгуулсан ус ашиглах гэрээний хуулбар, төлбөр төлсөн баримтын хуулбар

5.2.5. Химийн бодис импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл

5.2.6. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасны дагуу баталгаажсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.2.7. Энэ журмын 4 дүгээр бүлэгт заасны дагуу ирүүлсэн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн баталгаажсан тайлан

5.2.8. Байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн үл нийцлийг засч залруулах ажлын тайлан

5.2.9. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

5.3. Энэ журмын 5.2-т заасан мэдээллийг дор дурдсан хугацаанд дараахь албан тушаалтан оруулна.

5.3.1. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нарийвчилсан үнэлгээ батлагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудлыг хариуцсан нэгжийн мэргэжилтэн;

5.3.2. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасны дагуу баталгаажсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон энэ журмын 4 дүгээр бүлэгт заасны дагуу ирүүлсэн Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн баталгаажсан тайланг уг төлөвлөгөө, тайланг баталгаажсанаас хойш ажлын 5 хоногт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудлыг хариуцсан нэгжийн уул уурхайн байгаль хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн;

5.3.3. Байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн үл нийцлийг засч залруулсан ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад хүлээлгэн өгсөнөөс хойш ажлын 5 хоногт багтаан төсөл хэрэгжүүлэгч;

5.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төв мэдээллийн санд нэвтрэх, ашиглах

5.4.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө хариуцсан газар, хэлтэс байгаль орчны менежментийн төлөвлөгөөний мэдээллийн санд нэвтрэх, ашиглах эрхтэй байх бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө хариуцсан газар эсхүл хэлтсийн дарга мэдээллийн санг эрхлэх бөгөөд газрын байгаль орчны менежментийн төлөвлөгөө хариуцсан мэргэжилтнүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэрхэн, хэзээ авч хүлээн авч, журамд заасан хугацаанд ямар хариу өгч, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг тодорхой оруулна.

5.5. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний мэдээллийн санд нэвтрэх, ашиглах

5.5.1. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний мэдээллийн санд нэвтрэх, ашиглах эрхтэй байх бөгөөд уг асуудлыг хариуцсан мэргэжилтэн төсөл хэрэгжүүлж буй иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүлээн авсанаас хойш журамд заасан хугацаанд хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг тодорхой оруулна.

5.6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, түүний хавсралт материалуудыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд 12 дүгээр сарын 1-ний дотор, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 дугаар сарын 31-ний дотор баримт бичгийг *.pdf өргөтгөлтэйгөөр, сэдэвчилсэн газрын зургийн хувьд *.pdf болон *.shp өргөтгөлтэйгөөр оруулсан байна.

Зургаадугаар бүлэг. Бусад

6.1. Энэ журмын 5.3.1, 5.3.2, 5.3.3 – т заасан заалтыг хэрэгжүүлээгүй тохиолдол бүр нь тухайн асуудал хариуцсан ажилтанд сахилгын хариуцлага ногдуулах үндэслэл болно.

6.2. Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх барьцаа хөрөнгийг төвлөрүүлэх, буцаан олгохтой холбогдсон харилцааг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.15-д заасан журмаар зохицуулна.

6.3. Өмнөх оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хүлээн авч дүгнэх, дараа жилийн төлөвлөгөөг хянан батлах асуудлыг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага материал хүлээн авсанаас хойш ажлын 21 хоногт багтааж, шийдвэрлэнэ.

6.4. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалган, дүгнэлт гаргахтай холбоотой гомдлоо 2 дугаар сарын 15-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага уг гомдлыг хүлээж авч, асуудлыг газар дээр үзэж танилцаж, хөндлөнгийн дүгнэлт гаргах ажлын хэсгийг тухайн төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага, байгаль орчны аудитын байгууллагын төлөөлөл, төв, орон нутаг дахь байгаль орчны хяналт шинжилгээ хариуцсан байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг томилж, дүгнэлт гаргуулан 1 сарын дотор шийдвэрлэнэ.

----- оОо -----

ТӨСӨӨЛ

Журмын 1 дүгээр хавсралт. А. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний баталгаажих нүүр хуудасны загвар

Батлав. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга

_____ / _____ /

эсвэл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын дарга)

_____ / _____ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

_____ ХХК-ийн захирал _____

_____ -ЫН

(төслийн байршил, нэр)

_____ онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хянасан:

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн _____

эсвэл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн) _____

Боловсруулсан:

_____ ХХК-ийн байгаль орчны хэлтсийн дарга эсвэл байгаль орчны мэргэжилтэн _____

Б. Ашигт малтмал, газрын тосны хайгуулын төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний баталгаажих нүүр хуудасны загвар

Батлав:

_____/_____/_____
_____ аймаг, нийслэлийн байгаль
орчны асуудал эрхэлсэн байгууллагын дарга

Батлав:

_____/_____/_____
_____ аймгийн
_____ сумын Засаг дарга

_____ аймгийн _____ сумын
нутагт орших _____ ХХК-ийн
“_____” (_____) хайгуулын тусгай
зөвшөөрлийн талбайд 20__ онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө

Хянасан:

_____ аймгийн _____
сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч _____/_____

Танилцаж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: _____ ХХК

Гүйцэтгэх захирал _____/_____

Боловсруулсан:

_____ ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн _____
/_____/

20__ он

Журмын 2 дугаар хавсралт.

А. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нүүр хуудасны жишиг загвар

_____ -ЫН
(төслийн байршил, нэр)

20__ онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хянасан:

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудлыг эрхэлсэн газрын тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн _____
/ _____ /

эсвэл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын мэргэжилтэн)

/ _____ /

Хэрэгжилтийг гаргасан:

_____ ХХК-ийн гүйцэтгэх захирал _____ / _____ /

_____ ХХК-ийн байгаль орчны хэлтсийн захирал _____
/ _____ / эсвэл мэргэжилтэн _____ / _____ /

20____OH

Б. Ашигт малтмал, газрын тосны хайгуулын төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нүүр хуудасны жишиг загвар

Батлав:

_____/_____/_____
_____/_____/_____
_____ аймаг, нийслэлийн байгаль
орчны асуудал эрхэлсэн байгууллагын дарга

Батлав:

_____/_____/_____
_____/_____/_____
_____ аймгийн
_____ сумын Засаг дарга

_____ аймгийн _____ сумын
нутагт орших _____ ХХК-ийн
“ _____ ” (_____) хайгуулын тусгай
зөвшөөрлийн талбайд 20____ онд хэрэгжүүлсэн байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хянасан:

_____ аймгийн байгаль орчны асуудал эрхэлсэн
байгууллагын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн _____/_____/_____

_____ аймгийн _____
сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч _____/_____/_____

Хэрэгжилтийг ханган ажилласан: _____ ХХК

Гүйцэтгэх захирал _____/_____/_____

Тайлан боловсруулсан:

_____ ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн
_____/_____/_____

20__ он

Журмын 3 дугаар хавсралт. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулга

A. Ашигт малтмалын хайгуулын төслийн тухай жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга

1. Төслийн товч танилцуулга
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		20.. он				
		Сар ...	Сар ...	Сар ...		

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар

ТӨСӨӨ

Б. Уул уурхайн олборлох төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга

1. Төслийн товч танилцуулга
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

